



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны II улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын
IV байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	3
Зургийн жагсаалт.....	4
Товчилсон нэрсийн жагсаалт	4
Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал.....	5
Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт	6
Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт.....	7
Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт	7
Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт	7
“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт	7
Статистик үзүүлэлтүүд	8
Харилцагчид, зээлдэгчид	8
Хувьцаа эзэмшигчид болон ажилчид	8
Тархалт	9
Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт.....	10
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө.....	11
Хөрөнгө оруулалт	11
Зээл.....	12
Цахим зээл	15
Ногоон зээл	16
Факторингийн тооцооны авлага.....	17
Үүсмэл санхүүгийн хөрөнгө, бусад санхүүгийн хөрөнгө.....	17
Санхүүгийн бус хөрөнгө	18
Пассивын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт	19
Итгэлцлийн үйлчилгээний өглөг.....	20
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр.....	21
Бусад эх үүсвэр	21
ББСБ-аас гаргасан өрийн бичиг.....	22
Төслийн зээлийн санхүүжилт	22
Бусад санхүүгийн өр төлбөр.....	23
Санхүүгийн бус өр төлбөр	23
Өөрийн хөрөнгө	23
Хувь нийлүүлсэн хөрөнгө.....	24
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	25
Хуримтлагдсан ашиг	25
Ашигт ажиллагаа	26
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд.....	27
Дүгнэлт	28
Актив, пассивын бүтэц.....	28
Ашигт ажиллагаа	29
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт.....	29

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл	5
Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/	5
Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа	5
Хүснэгт 5 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл.....	8
Хүснэгт 6 Статистик мэдээлэл /5 жилээр/.....	8
Хүснэгт 7 ББСБ-ын мэдээлэл	9
Хүснэгт 8 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа.....	9
Хүснэгт 9 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт	9
Хүснэгт 10 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт	9
Хүснэгт 11 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	10
Хүснэгт 12 Активын интервал /тэрбум төгрөгөөр/	11
Хүснэгт 13 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	11
Хүснэгт 16 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/.....	12
Хүснэгт 17 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	12
Хүснэгт 18 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/.....	14
Хүснэгт 19 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/.....	14
Хүснэгт 20 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)	15
Хүснэгт 21 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд	15
Хүснэгт 23 Ногоон зээлийн тайлан /сая төгрөгөөр/	16
Хүснэгт 24 Факторингийн тооцооны авлагын ангилал /сая төгрөгөөр/.....	17
Хүснэгт 25 Бусад хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/	17
Хүснэгт 26 Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/	18
Хүснэгт 27 Пассивын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/	19
Хүснэгт 28 Итгэлцлийн үйлчилгээ /сая төгрөгөөр/	21
Хүснэгт 30 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг /тэрбум төгрөгөөр/	21
Хүснэгт 31 Бусад эх үүсвэрийн бүтэц /сая төгрөгөөр/.....	21
Хүснэгт 33 Төслийн зээл санхүүжилт /сая төгрөгөөр/.....	22
Хүснэгт 34 Бусад өр төлбөр /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 35 Санхүүгийн бус өр төлбөр /сая төгрөгөөр/	23
Хүснэгт 36 Өөрийн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/.....	23
Хүснэгт 37 Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц /сая төгрөгөөр/	24
Хүснэгт 38 ХНХ-ийн интервал /тэрбум төгрөгөөр/	25
Хүснэгт 39 Бусад өмч, сангуудын бүтэц /сая төгрөгөөр/	25
Хүснэгт 40 Хуримтлагдсан ашиг/алдагдал /тэрбум төгрөгөөр/	25
Хүснэгт 41 Орлого, үр дүнгийн тайлан /харьцуулсан, сая төгрөгөөр/.....	26
Хүснэгт 42 Орлого, үр дүнгийн тайлан /сая төгрөгөөр/	26
Хүснэгт 43 ЗХШҮ /үзүүлэлт бүрээр/.....	27

Зургийн жагсаалт

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл).....	10
Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	10
Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	11
Зураг 5 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	13
Зураг 6 Зээлийн багцын чанар /хувиар/	13
Зураг 7 Олгосон зээл /хугацааны ангиллаар/	14
Зураг 8 Ногоон зээлийн багцын чанар /ногоон таксономийн 12 ангиллаар/	17
Зураг 9 Банкны салбарт эзлэх хувь (өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг).....	19
Зураг 10 Пассивын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	20
Зураг 11 Итгэлцлийн үйлчилгээний өглөг /тэрбум төгрөгөөр/	20
Зураг 12 Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	22
Зураг 13 Хувьцаат капиталын бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/	24
Зураг 14 Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	26

Товчилсон нэрсийн жагсаалт

Товчилсон нэр	Тайлбар
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
ЗГВА	Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг
УБ	Улаанбаатар хот
ХОН	Хөдөө орон нутаг
ГХО	Гадаадын хөрөнгө оруулалттай
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
БХХО	Богино хугацаат хөрөнгө оруулалт
ӨБҮХХ	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө
ЗЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЗХШҮ	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын ерөнхий төлөв байдал

2024 оны II улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 549 ББСБ байгаа нь өмнөх оны мөн үеэс 27 ББСБ буюу 5.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 99 нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 26 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 5 ББСБ байна.

Хүснэгт 1 ББСБ-уудын тоо мэдээлэл

	2020-II	2021-II	2022-II	2023-II	2024-II
Шинээр олгосон	12	7	11	19	33
Хүчингүй	8	3	18	8	13
Түдгэлзүүлсэн	25	1	41	2	11
Сэргээсэн	4	5	9	16	12
Нийт ББСБ	542	536	527	522	549
Үүнээс: ХОН	77	79	89	95	99
Үүнээс: ГХО	31	30	27	25	26
Салбар	278	308	405	445	455
Төлөөлөгч	9	8	7	9	12

2024 оны II улирлын байдлаар 33 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 13 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 11 ББСБ-ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 12 ББСБ-ын үйл ажиллагааг сэргээсэн байна.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгохоос гадна уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 2024 оны II улирлын байдлаар 56 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 2 Банкны салбартай харьцуулсан ерөнхий үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2023-II	2024-II	Өсөлтийн хувь
Нийт хөрөнгө	3,945.9	5,756.6	45.9%
Банкны салбартай харьцуулахад хувиар	8.2%	9.3%	1.1%
Нийт өөрийн хөрөнгө	2,468.2	3,174.7	28.6%
Банкны салбартай харьцуулахад хувиар	49.4%	52.5%	3.1%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	1,440.0	1,682.2	16.8%
Банкны салбартай харьцуулахад хувиар	86.7%	101.6%	14.9%
Нийт зээл	3,107.5	4,590.5	47.7%
Банкны салбартай харьцуулахад хувиар	12.0%	13.6%	1.6%
Нийт орлого	520.2	800.9	54.0%
Нийт зарлага	331.1	475.8	43.7%
Цэвэр ашиг	189.1	325.1	71.9%

ББСБ-уудын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үеэс 45.9 хувиар өсөж, банкны салбарын 9.3%-тай тэнцэж байна. Харин хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ банкны салбарын 101.6%-тай тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.9 пунктээр өссөн дүн юм.

2024 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 45.9 хувиар буюу 1.8 их наяд төгрөгөөр өсөж 5.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Активын өсөлтийн 81.9 хувийг зээлийн өсөлт, пассивын өсөлтийн 39.0 хувийг өөрийн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад ББСБ-уудын нийт орлогын хэмжээ 54.0 хувиар буюу 280.7 тэрбум төгрөгөөр, нийт зардлын хэмжээ 43.7 хувиар буюу 144.7 тэрбум төгрөгөөр, цэвэр ашгийн хэмжээ 71.9 хувиар буюу 136.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3 ББСБ-уудын эрхэлж буй үйл ажиллагаа

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өөрчлөлт	
		2023-II	2024-II	Тоо	Хувь
	Нийт ББСБ-ын тоо	522	549	27	5.2%
1	Зээл	481	486	5	1.0%
	<i>Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>	339	297	-42	-12.4%
2	Факторингийн үйлчилгээ	50	57	7	14.0%
3	Төлбөрийн баталгаа гаргах	29	28	-1	-3.4%
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	6	-	-
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	42	51	9	21.4%
6	Гадаад валютын арилжаа	143	173	30	21.0%
	<i>Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>	39	60	21	53.8%
7	Итгэлцлийн үйлчилгээ	82	85	3	3.7%
8	Богино хугацааг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	26	42	16	61.5%
9	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	-	-

Үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 549 ББСБ 9 төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж байна. Нийт ББСБ-уудын 88.5% нь буюу 486 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ба үүнээс 54.1% нь буюу 297 ББСБ дагнан эрхэлж байна. Харин гадаад валютын

арилжааны үйл ажиллагаа эрхэлж байгаа 173 ББСБ байгаа нь нийт ББСБ-уудын 31.5 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа 60 ББСБ нийт ББСБ-уудын 10.9 хувийг бүрдүүлж байна.

Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг болон төлбөрийн баталгаа гаргах ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс харгалзан 12.4 хувь болон 3.4 хувиар буурч, бусад төрлийн үйл ажиллагааны тоо нэмэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл гадаад валютын арилжаа 30 ББСБ-аар буюу 21.0 хувиар, богино хугацаат санхүүгийн

хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээ 16 ББСБ-аар буюу 61.5 хувиар, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ 9 ББСБ-аар буюу 21.4 хувиар, факторингийн үйлчилгээ 7 ББСБ-аар буюу 14.0 хувиар тус тус өссөн байна.

2024 оны II улирлын тайлан мэдээний ирц 98.0% байна. Тайлан мэдээг ирүүлбэл зохих 549 ББСБ-аас 538 ББСБ улирлын тайлан мэдээ ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд нэр бүхий 4 ББСБ өмнөх үеийн тайлан тэнцлээр, нэр бүхий 7 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа.

Хууль, тогтоомж болон журмын өөрчлөлт, хэрэгжилт

ББСБ-ууд хөрөнгийн зах зээлд гарч, нээлттэй хувьцаат компани болох, банк банк бус санхүүгийн тодорхой нэр төрлийн үйл ажиллагааг эрхлэх, олон улсаас хөрөнгө оруулалт татах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн хэрээр нягтлан бодох бүртгэл, тайлагналыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэх, салбарын нягтлан бодох бүртгэлийн арга хандлагыг шинэчлэх, зайлшгүй шаардлага үүссэн. Үүний дагуу “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Сангийн сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/226/528 тоот тушаалаар шинэчлэн баталсан бөгөөд ББСБ-ууд энэхүү журмыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Шинэчлэн журамд төсөлд СТОУС-9 Санхүүгийн хэрэглүүр, СТОУС-13 Бодит үнэ цэнийн хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа зэрэг СТОУС, НББОУС-ын дагуу санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, ангилах, хэмжих, ажил гүйлгээний бүртгэлийг дэлгэрэнгүй байдлаар тусгасан.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын хэрэгжилт

2024 оны II улирлын байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулах үүргийг 94.2 хувь буюу 485 ББСБ, нийтэд мэдээлэх үүргийг 96.95 хувь буюу 470 ББСБ хэрэгжүүлсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилт

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу ББСБ-ууд нь Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдэд шаардлагатай мэдээллийг өгөх, авах, гэрээ байгуулж мэдээлэл солилцох үүрэгтэй.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй 486 ББСБ-ын 95.5 хувь буюу 464 ББСБ Монголбанк, “Бүрэн скор ЗМС” ХХК болон “Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн аль нэгтэй гэрээ байгуулсан байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Энэ хуулийн 4.1-д

заасан этгээд 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.” гэж заасны дагуу нэр бүхий 106 ББСБ, 5,457 удаагийн тохиолдлоор, 657.7 сая төгрөгийг, 7.2-т “Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ хуулийн 4.1-д заасан этгээд энэ тухай 24 цагийн дотор сэжигтэй гүйлгээний тухай батлагдсан маягт, журмын дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ.” гэж заасны дагуу нэр бүхий 6 ББСБ, 193 удаагийн тохиолдлоор, 2,474.0 сая төгрөгийг Монголбанкны СМА-нд тус тус мэдээлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн байна.

“Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-ын хэрэгжилт

2024 оны II улирлын байдлаар нийт 516 ББСБ-аас 1,292.98 сая төгрөгийн зохицуулалт үйлчилгээний хөлс төлөхөөс 98.5% буюу 506 ББСБ 1,273.9 сая төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Статистик үзүүлэлтүүд

2024 оны II улирлын байдлаар давхардсан тоогоор 33,910 хувьцаа эзэмшигчдийн 549 ББСБ, 455 салбар нэгж, 12 төлөөлөгчийн газар, 5,575 ажилтантайгаар Монгол улсын 21 аймаг, 8 дүүрэгт давхардсан тоогоор 4.9 сая харилцагч, 1.9 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

Харилцагчид, зээлдэгчид

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 26.2 хувиар өсөж давхардсан тоогоор 4,875,687-д, зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 43.9 хувиар өсөж 1,865,966-д хүрсэн байна.

Хүснэгт 4 Харилцагч, зээлдэгчдийн мэдээлэл

Статистик мэдээлэл	Дун	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Нийт харилцагчдын тоо	4,875,687	4,447,331	236,109	4,639,578	56,939	4,833,871	41,816	424,557	89,013
Үүнээс: Эмэгтэй	2,654,604	2,420,972	131,198	2,523,406	40,821	2,631,701	22,903	229,403	47,009
Эрэгтэй	2,217,127	2,025,246	101,712	2,115,415	14,301	2,198,286	18,841	194,854	41,683
Хуулийн этгээд	3,956	1,113	3,199	757	1,817	3,884	72	300	321
Итгэмжлэгчдийн тоо	12,036	12,034	2,354	9,682	-	12,003	33	5,965	355
Өрийн бичиг авсан харилцагчдын тоо	1,305	1,246	110	1,195	-	1,305	-	457	353
Зээлдэгчдийн тоо	1,865,966	1,496,130	175,978	1,689,988	49	1,825,997	39,969	193,491	89,013
Хэвийн	1,678,508	1,356,803	149,129	1,529,379	20	1,645,662	32,846	166,838	78,482
Хугацаа хэтэрсэн	55,376	42,319	4,851	50,525	-	53,494	1,882	8,560	2,722
Чанаргүй:	132,082	97,008	21,998	110,084	29	126,841	5,241	18,093	7,809
-Хэвийн бус	34,034	23,113	3,695	30,339	7	32,518	1,516	5,353	2,609
-Эргэлзээтэй	31,932	23,318	3,244	28,688	3	30,632	1,300	5,690	2,501
-Муу	66,116	50,577	15,059	51,057	19	63,691	2,425	7,050	2,699
Зээлдэгчдийн насжилт	1,863,914	1,495,051	174,648	1,689,266	49	1,824,013	39,901	193,181	88,692
18-35 насны	1,146,516	931,364	71,498	1,075,018	49	1,122,912	23,604	113,643	50,406
36-45 насны	461,750	355,906	57,034	404,716	-	451,971	9,779	50,692	23,134
46-55 насны	202,001	163,700	33,050	168,951	-	197,114	4,887	21,858	11,136
55-аас дээш	53,647	44,081	13,066	40,581	-	52,016	1,631	6,988	4,016
Зээлдэгчдийн боловсрол	1,863,914	1,495,051	174,648	1,689,266	49	1,824,013	39,901	193,181	88,692
-Дээд	967,205	756,207	89,066	878,139	49	948,344	18,861	108,697	57,589
-Тусгай дунд	166,870	133,652	17,976	148,894	-	162,557	4,313	17,972	12,003
-Бүрэн дунд	540,192	447,644	44,130	496,062	-	525,207	14,985	56,586	12,983
-Дунд	138,282	113,538	15,231	123,051	-	137,081	1,201	7,977	4,665
-Бага	51,365	44,010	8,245	43,120	-	50,824	541	1,949	1,452

/Финтек ББСБ-ууд финтек уламжлалт зээл хослуулан олгодог болно/

Нийт харилцагчдын 95.2% буюу 4,639,578 нь, зээлдэгчдийн 90.6% буюу 1,689,988 нь санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж /финтек/, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлж буй ББСБ-уудын харилцагч, зээлдэгч байгаа бол нийт харилцагчдын 4.8% буюу 236,109 нь, зээлдэгчдийн 9.4% буюу 175,978 нь уламжлалт ББСБ-ын харилцагч, зээлдэгч байна. Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг ББСБ-уудын харилцагчид 56,939 буюу нийт харилцагчдын 1.2 хувийг бүрдүүлж байна.

Хувьцаа эзэмшигчид болон ажилчид

Хүснэгт 5 Статистик мэдээлэл /5 жилээр/

Үзүүлэлтүүд	2020-II	2021-II	2022-II	2023-II	2024-II	Өөрчлөлт	
						Дүнгээр	Хувиар
Хувьцаа эзэмшигчдийн тоо	8,404	21,486	22,378	28,366	33,910	5,557	19.6%
Ажилчдын тоо	3,372	3,713	4,279	5,012	5,575	840	17.7%
Харилцагчдын тоо	2,766,913	3,292,164	4,748,336	3,895,981	4,875,687	1,013,198	26.2%
Зээлдэгчдийн тоо	445,984	748,270	1,518,497	1,322,326	1,865,966	568,941	43.9%
Зээлийн жигнэсэн дундаж хүү	2.9%	2.9%	3.1%	3.3%	%	+0.2%	

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо өмнөх оны мөн үеэс 19.6 хувиар буюу 5,557-оор өсөж 33,910-д хүрчээ. Нийт хувьцаа эзэмшигчдийн 96.8 хувь буюу 32,810 нь олон нийтэд хувьцаагаа санал болгосон ББСБ-уудын хувьцаа эзэмшигч байгаа бол 1,100 буюу 3.2% нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид байна. Мөн хувьцаа эзэмшигчдийн 2,776 буюу 8.2% нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байгаа бол 224 буюу 0.7% нь хөдөө орон нутгийн ББСБ-уудын хувьцаа эзэмшигчид байна.

Хүснэгт 6 ББСБ-ын мэдээлэл

Статистик мэдээлэл	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ГХО
Хувьцаа эзэмшигчдийн тоо	33,910	33,022	1,941	31,969	83	33,686	224	32,810	2,776
Нийт ажилтнуудын тоо	5,575	3,392	2,673	2,902	156	5,270	305	497	469
Үүнээс: Эмэгтэй ажилтны тоо	3,294	1,980	1,623	1,671	85	3,089	205	323	299
Эрэгтэй ажилтны тоо	2,281	1,412	1,050	1,231	71	2,181	100	174	170

Хөдөө орон нутгийн 99 ББСБ 7 төрлийн тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 7 Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа

	НИЙТ	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВА	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
ТЗ-тэй ББСБ-ын тоо	549	85	493	56	60	450	99	5	544	26
1 Зээл	486	85	430	56	-	392	94	5	481	25
2 Факторингийн үйлчилгээ	57	30	38	19	-	54	3	3	54	1
3 Төлбөрийн баталгаа гаргах	28	17	21	7	-	27	1	2	26	3
4 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	5	-	6	-	6	-	1	5	-
5 Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	51	23	31	20	-	48	3	3	48	2
6 Гадаад валютын арилжаа	173	35	150	23	60	157	16	4	169	8
7 Итгэлцлийн үйлчилгээ	85	85	51	34	-	81	4	5	80	5
8 Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	42	25	26	16	-	40	2	3	39	4
9 Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	1	1	1	-	-	1	-	-	1	1

Тархалт

Улаанбаатар хотод нийт ББСБ-уудын 82.0% буюу 450 ББСБ, салбаруудын 59.8% буюу 272 салбар байршиж байна. Харин хөдөө орон нутагт нийт ББСБ-ын 18.0% буюу 99 ББСБ, салбаруудын 40.2% буюу 183 салбар бүртгэлтэй үйл ажиллагаа эрхэлж байна.

2024 оны II улирлын байдлаар 105 ББСБ-ын 455 салбар бүртгэлтэй байгаа ба эдгээрийн 59.6 хувийг 13 ББСБ-ын 271 салбар бүрдүүлж байна.

Хүснэгт 8 Улаанбаатар хотын ББСБ-уудын тархалт

Дүүрэг	Үндсэн 450	Салбар 272	Нийт 722	Хувь 100.0%
1. Сүхбаатар дүүрэг	148	39	187	25.9%
2. Чингэлтэй дүүрэг	127	28	155	21.5%
3. Баянзүрх дүүрэг	50	68	118	16.3%
4. Баянгол дүүрэг	73	38	111	15.4%
5. Хан-Уул дүүрэг	42	34	76	10.5%
6. Сонгинохайрхан дүүрэг	9	53	62	8.6%
7. Багануур дүүрэг	1	7	8	1.1%
8. Налайх дүүрэг	-	5	5	0.7%

ББСБ-ууд хөдөө орон нутгаас Орхон, Төв, Өвөрхангай аймгуудад, Улаанбаатар хотоос Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд хамгийн ихээр төвлөрч үйлчилгээгээ хүргэж байна.

Хүснэгт 9 Хөдөө орон нутгийн ББСБ-уудын тархалт

Аймаг	Үндсэн 99	Салбар 183	Нийт 282	Хувь 100%
Архангай аймаг	3	7	10	3.5%
Баян-Өлгий аймаг	3	4	7	2.5%
Баянхонгор аймаг	4	8	12	4.3%
Булган аймаг	2	2	4	1.4%
Говь-Алтай аймаг	1	2	3	1.1%
Говьсүмбэр аймаг	3	4	7	2.5%
Дархан-Уул аймаг	8	13	21	7.4%
Дорноговь аймаг	1	10	11	3.9%
Дорнод аймаг	5	14	19	6.7%
Дундговь аймаг	-	6	6	2.1%
Завхан аймаг	3	5	8	2.8%
Орхон аймаг	12	19	31	11.0%
Өвөрхангай аймаг	11	13	24	8.5%
Өмнөговь аймаг	2	16	18	6.4%
Сүхбаатар аймаг	5	7	12	4.3%
Сэлэнгэ аймаг	8	12	20	7.1%
Төв аймаг	18	6	24	8.5%
Увс аймаг	4	8	12	4.3%
Ховд аймаг	1	7	8	2.8%
Хөвсгөл аймаг	2	10	12	4.3%
Хэнтий аймаг	3	10	13	4.6%

Активын бүтэц, бүрэлдэхүүн, өөрчлөлт


2024 оны II улирлын байдлаар банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 5.8 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45.9 хувиар буюу 1.8 их наяд төгрөгөөр өсжээ. Активын өсөлтийн 89.9 хувийг нийт зээлийн өсөлт бүрдүүлж байна. Активын үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл:

Хүснэгт 10 Активын үзүүлэлтүүд /сая төгрөгөөр/

Активын үзүүлэлтүүд	2023-I		2024-I		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,815,144.8	96.7%	5,490,485.7	95.4%	1,675,340.9	43.9%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	524,573.9	13.3%	706,663.0	12.3%	182,089.1	34.7%
Хөрөнгө оруулалт	34,911.5	0.9%	76,956.9	2.0%	42,045.4	120.4%
Зээл (цэврээр)	2,929,953.4	74.3%	4,558,254.8	115.5%	1,628,301.4	55.6%
Факторингийн тооцооны авлага (цэврээр)	10,247.3	0.3%	21,896.9	0.6%	11,649.6	113.7%
Үүсмэл санхүүгийн хөрөнгө	5,148.8	0.1%	1,333.6	0.0%	(3,815.2)	-74.1%
Бусад санхүүгийн хөрөнгө	310,309.9	7.9%	125,380.5	3.2%	(184,929.4)	-59.6%
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	130,753.7	3.3%	266,099.7	6.7%	135,346.0	103.5%
Санхүүгийн бус бусад хөрөнгө			99,178.4	2.5%	99,178.4	-
Үндсэн хөрөнгө (цэврээр)	130,753.6	3.3%	124,020.7	3.1%	36,167.7	27.7%
Биет бус хөрөнгө (цэврээр)			42,900.6	1.1%		
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,945,898.5	100.0%	5,756,585.4	145.9%	1,810,686.9	45.9%


2024 оны II улирлын байдлаар ББСБ-уудын нийт актив банкны салбарын нийт активын 9.3 хувьтай, нийт зээлийн үлдэгдэл 13.6 хувьтай тэнцэж байна.

Зураг 1 Банкны салбарт эзлэх хувь (нийт актив, зээл)



Сүүлийн 5 жилийн активын үзүүлэлтийг харвал салбарын нийт актив 2019 оны мөн үед 1,533.1 тэрбум төгрөг байсан бол 2024 оны II улирлын байдлаар 3.8 дахин өсөж 5,756.6 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь цэвэр зээлийн үлдэгдэл 4.2 дахин өссөнтэй холбоотой.

Зураг 2 Активын үзүүлэлтүүд сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Салбарын нийт хөрөнгийн 97.7% нь 2.5 тэрбум төгрөг ба түүнээс дээш хөрөнгөтэй 383 ББСБ, 0.9% нь 1.9-2.5 тэрбум төгрөг хүртэлх активтай 23 ББСБ байгаа бол нийт салбарын хөрөнгийн 1.4 хувийг 1.9 тэрбум төгрөг хүртэлх активтай 143 ББСБ-ын хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 11 Активын интервал /тэрбум төгрөгөөр/

Интервал	Нийт		Эзлэх хувь		Дархан, Эрдэнэт		Бусад аймаг, сумд		ЗГВА	
	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо	Актив	ББСБ тоо
5.0 тэрбумаас дээш	4,840.3	142	84.1%	25.9%	12.1	1	7.4	1	-	-
2.5-5.0 тэрбум	785.5	241	13.6%	43.9%	11.7	3	14.3	4	5.5	2
1.9-2.5 тэрбум	52.4	23	0.9%	4.2%	-	-	4.3	2	4.6	2
1.4-1.9 тэрбум	14.2	9	0.2%	1.6%	2.9	2	9.6	6	-	-
0.6-1.4 тэрбум	30.7	32	0.5%	5.8%	10.5	12	10.9	11	8.1	8
0.6 тэрбум хүртэлх	33.5	102	0.6%	18.6%	-	-	16.5	54	17.0	48
НИЙТ	5,756.6	549	100.0%	100.0%	37.3	18	63.1	78	35.1	60

Салбарын хамгийн өндөр активтай 20 ББСБ-ын актив 3.2 их наяд төгрөг байгаа нь нийт активын 56.5 хувийг, нийт зээлийн үлдэгдэл 2.7 их наяд төгрөг байгаа нь нийт зээлийн үлдэгдлийн 58.3 хувийг бүрдүүлж байна.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө


Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 182.1 тэрбум төгрөгөөр буюу 34.7 хувиар өсөж 706.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Бүтцээр нь авч үзвэл 13.3% нь бэлэн мөнгө хэлбэрээр, 78.8% нь 3 хүртэлх сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад, 8.0% нь 3-аас дээш сарын хугацаатай банк, санхүүгийн байгууллагад байршиж байна.

Хүснэгт 12 Мөнгөн хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Дүн	Итгэлцэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	706.7	406.6	362.2	344.4	32.1	687.5	19.2	155.6	162.3
Бэлэн мөнгө	93.7	6.1	88.1	5.6	22.1	85.1	8.6	0.2	3.2
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	556.8	372.8	243.9	313.0	9.5	547.1	9.7	153.6	152.7
Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8.2	4.4	4.9	3.3	-	8.1	0.0	0.1	0.1
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө (3-аас дээш сарын хугацаатай)	47.9	23.4	25.4	22.6	0.5	47.1	0.9	1.7	6.3

ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл уламжлалт үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 24.3%, финтек ББСБ-уудын мөнгөн хөрөнгийн 1.6%, эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос хамаарч гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын 69.1% нь бэлэн мөнгө хэлбэрээр тус тус байршиж байна.

Зураг 3 Мөнгөн хөрөнгийн бүтэц сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөгөөр/



Хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 2.2 дахин буюу 42.0 тэрбум төгрөгөөр өсөж, 2024 оны II улирлын байдлаар 35 ББСБ 77.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан байна. Хөрөнгө оруулалтын 0.5% буюу 412.0 сая төгрөгийг хадгаламжийн

сертификат, 99.5% буюу 76.5 тэрбум төгрөгийг үнэт цаасаарх хөрөнгө оруулалт бүрдүүлж байна.

Хүснэгт 13 Богино хугацаат хөрөнгө оруулалтын бүтэц /сая төгрөгөөр/

	Дүн	Итгэлцлэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	76,956.9	73,617.0	5,916.7	71,040.2	1.0	76,037.3	919.6	43,902.7	39,005.5
Хадгаламжийн сертификат	412.0	402.0	412.0	-	-	412.0	-	-	-
Үнэт цаас	76,544.9	73,215.1	5,504.8	71,040.2	1.0	75,625.3	919.6	43,902.7	39,005.5
Ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	43,247.6	40,717.2	3,338.3	39,909.3	1.0	42,328.0	919.6	19,154.9	18,650.2
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн үнэт цаас	11,669.5	11,669.5	1,214.2	10,455.3	-	11,669.5	-	4,255.3	-
Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	20,197.6	20,197.6	152.9	20,044.7	-	20,197.6	-	20,044.7	20,044.7
Барьцаанд байгаа үнэт цаас	399.4	-	399.4	-	-	399.4	-	-	-
Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,030.8	630.8	400.0	630.8	-	1,030.8	-	447.7	310.6
(Үнэт цаасны эрсдэлийн сан)	110.4	110.4	-	110.4	-	110.4	-	-	-

Тайлант улиралд богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрөлтэй 42 ББСБ бүртгэлтэй байгаа хэдий ч 35 ББСБ санхүүгийн тайлангаар хөрөнгө оруулалтын үлдэгдэлтэй гарсан ба эдгээрийн 28 ББСБ нь тусгай зөвшөөрөлтэй байна.

Тусгай зөвшөөрөлгүй энэхүү үйл ажиллагааг эрхэлсэн 7 ББСБ байгаа тул Зөрчлийн тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Зээл

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 55.6% буюу 1.6 тэрбум төгрөгөөр өсөж 2024 оны II улирлын байдлаар 4.8 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 212.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 4.6 их наяд төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 14 Зээлийн бүтэц /тэрбум төгрөгөөр/

	Дүн	Итгэлцлэл	Уламжлалт	Финтек	ЗГВ	УБ	ХОН	ХК	ГХО
Зээл (цэврээр)	4,558,254.81	3,352,760.22	1,892,298.62	2,665,956.19	1,895.47	4,484,932.94	73,321.87	817,703.72	648,877.58
Зээл	4,772,255.59	3,488,141.92	1,995,131.28	2,777,124.31	1,986.84	4,692,035.05	80,220.54	848,656.29	677,136.26
Хэвийн	4,169,704.10	3,110,382.36	1,685,839.09	2,483,865.01	1,831.15	4,103,543.78	66,160.33	759,114.74	598,083.50
Анхаарал хандуулах	137,946.85	94,501.86	65,485.65	72,461.20	-	135,362.76	2,584.09	25,034.52	20,528.03
Чанаргүй зээл	282,820.59	174,932.09	145,805.52	137,015.07	155.69	273,962.10	8,858.49	39,531.78	37,677.62
-Хэвийн бус зээл	78,789.10	51,874.55	39,856.38	38,932.71	82.55	77,334.95	1,454.15	16,844.35	14,091.91
-Эргэлзээтэй зээл	65,007.56	41,561.32	32,989.81	32,017.75	4.81	62,800.64	2,206.92	12,100.55	9,723.57
-Муу зээл	139,023.94	81,496.23	72,959.33	66,064.61	68.32	133,826.51	5,197.42	10,586.87	13,862.14
(ЗЭС)	212,432.92	135,381.70	101,264.80	111,168.12	91.37	205,534.24	6,898.68	30,952.57	26,690.82
Хойшлогдсон төлбөр	2,080.75	1,985.35	119.73	1,961.02	-	2,080.75	-	1,927.76	1,927.76
Зээлд хур/ тооцсон хүүгийн авлага	183,864.79	110,310.96	98,120.74	85,744.05	-	181,247.16	2,617.63	26,903.01	22,774.87
ЗЗ-ийн хүүнээс доогуур хүүтэйгээр олгосон зээлийн бодит үнийн залруулга	1,567.86	-	1,567.86	-	-	1,567.86	-	-	1,567.86

(Финтек ББСБ-ууд уламжлалт зээл давхар олгодог болно)

Шинэчлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд зааснаар “Санхүүгийн тайланд зээлийг хорогдуулсан өртгөөр хэмжиж, тайлагнана. Зээлийн хорогдуулсан өртөг нь зээлийг анх хүлээн зөвшөөрч хэмжсэн дүнгээс буцаан төлсөн зээлийн үндсэн төлбөрийн төлөлтийг хасаж, хойшлогдсон орлого, зардлыг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулан хуримтлуулсан дүнг хасах, эсхүл нэмж, зээлийн эрсдэлийн санг хассан дүн байна” гэж тодорхойлсон.

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг 1 ББСБ 2.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан ба тухайн ББСБ-ын зээлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 2024.03.20-ны өдрийн тогтоолоор хүчингүй болгосон байна. Тайлант улиралд ББСБ-ууд 5.5 их наяд төгрөгийн зээлийг 3.5 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр олгож, 4.6 их наяд

төгрөгийн зээл эргэн төлөгдөж, 2024 оны II улирлын байдлаар 1.9 сая зээлдэгчийн 4.6 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй гарсан байна.


Зураг 4 Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



(Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн багцын нийлбэрээр тооцсон)

Зээлийн багцын 90.8 хувийг буюу 4.2 их наяд төгрөгийг хэвийн зээл, 3.0 хувийг буюу 137.9 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 6.2 хувийг буюу 282.8 тэрбум төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 5 Зээлийн багцын чанар /хувиар/



Нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр өссөн бол анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ харгалзан 0.3, 1.5 пунктээр буурсан байна. Анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн 420.8 тэрбум төгрөгийн үлдэгдлийн 50.5 хувьд буюу 212.4 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан байна.

2024 оны II улирлын байдлаар нийт зээлд эзлэх анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн хэмжээ 9.2% байна.

Олгосон зээлийн 93.4% буюу 5.1 их наяд төгрөгийн зээлийг иргэдэд, 6.6% буюу 361.6 тэрбум төгрөгийн зээлийг хуулийн этгээдэд олгосон байгаа бол 93.4% буюу 4.3 их наяд төгрөг нь иргэдээс, 6.6% нь буюу 301.8 тэрбум төгрөг нь хуулийн этгээдээс эргэн төлөгдсөн байна.

Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга нарын хамтарсан 2018 оны 12-р сарын 31-ний өдрийн 319/А/16 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-аар нийт олгосон зээлийн 81.3% буюу 4.4 их наяд төгрөг нь бусад ангилалд /ихэвчлэн хэрэглээний зээл/, 8.0% буюу 437.8 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгогдсон бол нийт төлөгдсөн зээлийн 81.7% буюу


3.7 их наяд төгрөг нь бусад ангиллын зээлээс, 7.5% буюу 344.7 тэрбум төгрөг нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт олгосон зээлээс эргэн төлөгджээ.

Хүснэгт 15 Олгосон болон төлөгдсөн зээл салбараар /сая төгрөгөөр/

№	Зээлийн эдийн засгийн ангилал	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	28,898.3	0.53%	17,746.3	0.4%	45,747.1	1.0%
2.	Уул уурхай, олборлолт	31,355.4	0.6%	25,239.6	0.6%	61,579.9	1.3%
3.	Боловсруулах үйлдвэрлэл	29,342.6	0.5%	20,881.9	0.5%	41,231.5	0.9%
4.	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	4,304.0	0.1%	3,890.2	0.1%	6,049.3	0.1%
5.	Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	2,354.4	0.0%	976.5	0.0%	3,719.6	0.1%
6.	Барилга	121,992.8	2.2%	104,179.2	2.3%	258,586.4	5.6%
7.	Бөөний болон жижиглэн худалдаа	437,777.2	8.0%	344,751.5	7.5%	493,047.0	10.7%
8.	Машин мотоциклийн засвар үйлчилгээ	81,884.0	1.5%	76,691.1	1.7%	106,593.5	2.3%
9.	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	49,925.7	0.9%	45,137.5	1.0%	139,992.5	3.0%
10.	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	56,803.1	1.0%	48,733.4	1.1%	119,666.1	2.6%
11.	Мэдээлэл холбоо	5,595.6	0.1%	6,165.5	0.1%	10,868.0	0.2%
12.	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	108,882.2	2.0%	93,789.6	2.0%	86,588.3	1.9%
13.	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	13,638.8	0.2%	9,789.1	0.2%	32,604.7	0.7%
14.	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1,703.3	0.0%	1,362.3	0.0%	4,469.5	0.1%
15.	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	12,750.7	0.2%	12,028.2	0.3%	19,773.4	0.4%
16.	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	3,729.6	0.1%	1,728.2	0.0%	4,292.1	0.1%
17.	Боловсрол	18,097.4	0.3%	14,320.3	0.3%	20,116.9	0.4%
18.	Хүний эрүүл мэнд, нийгмийн үйл ажиллагаа	10,087.5	0.2%	11,882.3	0.3%	15,580.4	0.3%
19.	Бусад	4,442,446.7	81.3%	3,745,638.7	81.7%	3,119,965.3	68.0%
<i>Иргэнд олгосон зээл</i>		5,099,946.2	93.4%	4,283,134.2	93.4%	4,091,997.4	89.1%
<i>Хуулийн этгээдэд олгосон зээл</i>		361,623.3	6.6%	301,797.1	6.6%	498,474.1	10.9%
НИЙТ		5,461,569.5	100.0%	4,584,931.3	100.0%	4,590,471.5	100.0%

Тайлант улиралд олгосон 5.5 их наяд төгрөгийн зээлийг хугацааны ангиллаар харвал 1 сар хүртэлх хугацаатай олгосон зээл нийт зээлийн 27.1 хувийг, 6-12 сарын хугацаатай олгосон зээл нийт зээлийн 24.0 хувийг буюу хамгийн өндөр хувийг бүрдүүлж байна.

Зураг 6 Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Нийт зээлийн үлдэгдлийн ангиллаас харахад 4.6 их наядын зээлийн 54.9 хувийг иргэний хэрэглээний зээлийн үлдэгдэл, үүнээс 24.0 хувийг автомашинд зориулсан зээлийн үлдэгдэл, 10.9 хувийг хуулийн этгээдийн бизнесийн зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Хүснэгт 16 Зээлийн ангилал /тэрбум төгрөгөөр/

Зээлийн ангиллаар	Олгосон зээл		Төлөгдсөн зээл		Зээлийн үлдэгдэл	
	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
Иргэнд олгосон зээл	5,099.7	93.4%	4,283.1	93.4%	4,091.8	89.1%
Хэрэглээнд зориулсан зээл	3,705.9	67.9%	3,177.1	69.3%	2,521.8	54.9%
<i>Үүнээс: Автомашинд зориулсан зээл</i>	<i>809.7</i>	<i>14.8%</i>	<i>518.7</i>	<i>11.3%</i>	<i>1,100.8</i>	<i>24.0%</i>
Бизнес зориулсан зээл	673.3	12.3%	509.8	11.1%	945.8	20.6%
Үл хөдлөх эд хөрөнгөд зориулсан зээл	94.2	1.7%	74.6	1.6%	177.4	3.9%
Бусад зээл	626.3	11.5%	521.6	11.4%	446.8	9.7%
Хуулийн этгээдэд олгосон зээл	361.6	6.6%	301.8	6.6%	498.5	10.9%
Бизнесийн зээл	289.1	5.3%	235.3	5.1%	425.3	9.3%
Автомашин зээл	6.5	0.1%	6.3	0.1%	11.0	0.2%
Үл хөдлөх эд хөрөнгийн зээл	7.6	0.1%	5.6	0.1%	11.5	0.3%
Бусад зээл	58.5	1.1%	54.7	1.2%	50.6	1.1%
НИЙТ	5,461.6	100.0%	4,584.9	100.0%	4,590.5	100.0%

Цахим зээл

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй финтек зээлийн үйлчилгээг 2024 оны II улирлын байдлаар 56 ББСБ үзүүлж байна.

Хүснэгт 17 Зээлийн ангилал (мянган төгрөгөөр)

	Зээлийн дүн	Нийт дүнд эзлэх хувь	Зээлдэгчдийн тоо	Нийт дүнд эзлэх хувь	Дундаж зээл
Уламжлалт	3,598,933,995,113.5	78.4%	190,911	10.2%	18,851,370.5
Цахим зээл	991,537,549,739.0	21.6%	1,675,055	89.8%	591,943.3
Нийт	4,590,471,544,852.5	100.0%	1,865,966	100.0%	2,460,104.6

2024 оны II улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн аппликэйшний 1.7 сая зээлдэгчийн 991.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 89.8 хувь, нийт зээлийн үлдэгдлийн 21.6 хувийг бүрдүүлж байна. Зөвхөн аппликэйшнээр нэг зээлдэгчид дунджаар 591.9 мянган төгрөгийн зээл олгосон байгаа нь уламжлалт зээлийн дунджаас 31.8 дахин бага байна.

Хүснэгт 18 Цахим зээл олгож байгаа ББСБ-ууд

№	Финтек	Апп нэр	Бүртгүүлсэн огноо
1	"Соно финтек ББСБ" ХХК	Sono Mongolia	2023.03.03-№7/895
2	"Мобифинанс ББСБ" ХХК	Monpay	2023.06.20-№7/2540
3	"Инвескор хэтэвч ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.08-№7/1871
4	"Тус финтек ББСБ" ХХК	Tus fintech	2023.05.19-№7/2125
5	"Цогзолфинанс ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.23-нд мэдэгдсэн.
6	"Анлок капитал ББСБ" ХХК	Unlock Finance	2024.04.23-№7/1442
7	"Кэйш флов финанс ББСБ" ХХК	Tugrug App	2024.02.21-№7/632
8	"Лэндмн ББСБ" ХК	LendMN	2023.06.20-№7/2550
9	"Инвескор ББСБ" ХК	InvesCore	2023.08.25-№7/3350
10	"Ашид капитал ББСБ" ХХК	Simple.mn	2023.11.10-№7/4317
11	"Таван богд финанс ББСБ" ХХК	PayOn.mn	2023.07.04-№7/2826
12	"Нөмөр кредит ББСБ" ХХК	Numur	2023.03.03-№7/890
13	"ТОКИ ББСБ" ХХК	Toki	2023.06.20-№7/2549
14	"Ардкредит ББСБ" ХХК	Ard	2023.12.22-№7/4873
15	"Нэт капитал финанс корпораци ББСБ" ХХК	NetPay	2023.07.04-№7/2825
16	"Хатан суудал инвест ББСБ" ХХК	Zeely	2023.03.03-№7/894
17	"Очир ундраа ОМЗ ББСБ" ХХК	Opay MN	2023.08.25-№7/3351
18	"Дэвжих нэхий ББСБ" ХХК	Money-T	2023.12.22-№7/4870
19	"Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК	BiD	2023.08.25-№7/3353
20	"Номин юнити ББСБ" ХХК	OmniWay	2024.02.21-№7/634
21	"Соломон инвестментс ББСБ" ХХК	M credit	2023.11.10-№7/4319
22	"Гэрэлфинанс ББСБ" ХХК	Gerel	2023.05.08-№7/1872
23	"Мөнгөнзоос кредит ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.24-нд мэдэгдсэн.
24	"Сэнд эм эн ББСБ" ХХК	SendMN	2024.02.21-№7/636
25	"Энт кредит инвестмент ББСБ" ХХК	EntCreditMN	2023.03.03-№7/891
26	"Си И Си инвестмент ББСБ" ХХК	Pocket.mn	2024.04.24-нд мэдэгдсэн.
27	"Грийн-Инвестмент ББСБ" ХХК	Gate.mn	2023.07.04-№7/2827
28	"Хас хаан ББСБ" ХХК	ХАСХААН	2023.06.20-№7/2551
29	"Их Монгол кредит ББСБ" ХХК	Ikh Mongol Credit	2024.02.21-№7/633
30	"Жи Эс Би капитал ББСБ" ХХК	Prime	2024.02.21-№7/631
31	"Гурван зуун жар финанс ББСБ" ХХК	Minu pay	2023.07.04-№7/2822
32	"Жи би си си ББСБ" ХХК	E-zeel	2023.03.03-№7/889
33	"Зээл Эм Эн платформ ББСБ" ХХК	Zeel.mn	2023.07.04-№7/2828
34	"Есөн финанс ББСБ" ХХК	MetaLend	2023.08.25-№7/3352
35	"Нанокапитал ББСБ" ХХК	Nano Capital	2023.07.04-№7/2824
36	"Инвеско фанд ББСБ" ХХК	IF.mn	2023.08.25-№7/3349
37	"Изи пэй норбула ББСБ" ХХК	Easypay.mn	2023.12.22-№7/4867
38	"Монголиа импакт финанс ББСБ" ХХК	Qmoni	2023.08.25-№7/3356
39	"Онч-Энх ББСБ" ХХК	Ugloo	2023.03.30-№7/1297
40	"Девелопинг энтерпрениорал монголиа ББСБ" ХХК	DEM.mn	2024.05.30-№7/2045
41	"Микрокредит ББСБ" ХХК	Easy	2023.12.22-№7/4871
42	"Магна профит энд инвестмент ББСБ" ХХК	Magna.mn	2024.02.21-№7/635
43	"Эс ай си эй финанс ББСБ" ХХК	Khanguud	2023.12.22-№7/4872

44	"Есөн эрдэнэ финанс ББСБ" ХХК	Leasing.mn	2023.03.30-№7/1298
45	"Финрүүт-инвестмент ББСБ" ХХК	Pocket.mn	2023.05.24-нд мэдэгдсэн.
46	"Ньюстар финанс ББСБ" ХХК	Lite+Nsf.mn	2023.06.20-№7/2553 2023.06.20-№7/2552
47	"Сэндли ББСБ" ХХК	Sendly	2023.07.04-№7/2821
48	"Франкфурт капитал ББСБ" ХХК	Nar app	2023.07.04-№7/2823
49	"Омни капитал ББСБ" ХХК	Moni	2023.07.05-№7/2869
50	"Говьфинанс ББСБ" ХХК	CashOne	2023.08.25-№7/3354
51	"Гоулдман инвестмент групп ББСБ" ХХК	Goldpay	2023.08.25-№7/3355
52	"Дарь финанс ББСБ" ХХК	Pocket.mn	2024.03.01-нд мэдэгдсэн.
